



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/116/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2021 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: Утас: 70523020 Гэрээт ажилтан	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ц.Лүндэгмаа Цахим хаяг: auditlundegmaa@gmail.com
---	---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.24 № 1-6/110

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАН-ӨЛЗИЙ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	213,636,300.50	420,786,082.10
33	АВЛАГА	114,786,407.00	122,042,416.60
335	Бусад авлага	114,786,407.00	122,042,416.60
3351	Байгууллагаас авах авлага	114,786,407.00	122,042,416.60
35	БАРАА МАТЕРИАЛ	98,849,893.50	298,743,665.50
354	Хангамжийн материал	98,849,893.50	298,743,665.50
35410	Бичиг хэргийн материал	1,457,152.00	1,521,764.00
35420	Аж ахуйн материал	74,981,848.50	187,804,831.50
35440	Түлш, шатах гослох материал	481,893.00	4,301,070.00
35470	Бусад хангамжийн материал	21,929,000.00	105,116,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,641,868,033.52	1,676,277,315.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,641,868,033.52	1,676,277,315.64
392	Биет хөрөнгө	1,523,656,533.52	1,559,831,023.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,059,568,000.00	1,107,637,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(44,202,917.28)	(96,609,210.40)
39203	Авто-гээврийн хэрэгсэл	511,967,800.00	509,367,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(260,738,633.38)	(266,944,189.01)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	350,405,253.00	442,033,936.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(224,326,081.47)	(240,934,448.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	284,611,929.00	270,652,261.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(161,649,517.07)	(171,408,375.70)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,141,604.00	11,141,604.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,120,903.28)	(5,106,253.72)
393	Биет бус хөрөнгө	118,211,500.00	116,446,291.71
39301	Програм хангамж	44,100,000.00	41,586,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,412,499.94)	(12,463,708.19)
39303	Бусад биет бус хөрөнгө	88,324,000.00	87,824,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(800,000.06)	(500,000.10)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,855,504,334.02	2,097,063,397.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,842,603,082.02	2,097,063,397.74
51	Засгийн газрын хувь оролцоо	1,842,603,082.02	2,097,063,397.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,335,190,111.52	1,335,190,111.52
51101	Өмч: - төрийн	1,335,190,111.52	1,335,190,111.52
512	Хуримтлагдсан үр дүн	356,096,418.26	610,556,733.98
51210	Өмнөх үеийн үр дүн	356,096,418.26	356,096,418.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	254,460,315.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	151,316,552.24	151,316,552.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,842,603,082.02	2,097,063,397.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,981,600,390.00	3,533,186,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	335,630,500.00	189,105,970.00
120	Нийтлэг татварын бус орлого	335,630,500.00	-

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	335,630,500.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	335,620,500.00	-
121	Хөрөнгийн орлого		189,105,970.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	335,620,500.00	103,139,140.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал		85,966,830.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,645,969,890.00	3,344,080,230.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	358,893,790.00	644,246,536.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	129,961,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,931,927.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	335,961,863.00	514,284,636.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,287,076,100.00	2,699,833,694.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,287,076,100.00	2,699,833,694.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,606,315,952.39	3,274,943,701.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,606,315,952.39	3,274,943,701.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,572,341,511.39	3,249,187,982.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	987,566,284.00	1,199,815,506.00
210101	Үндсэн цалин	616,282,685.00	761,935,332.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,099,000.00	88,617,907.67
210105	Гэрээт ажлын хөлс	314,184,599.00	349,262,266.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,091,313.00	138,754,826.00
210201	Тэтгэврийн даатгал	80,571,680.00	94,058,477.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,154,048.00	11,065,750.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,241,357.00	8,728,241.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,803,351.00	2,108,971.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,320,877.00	22,793,387.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,139,865.00	234,782,791.00
210301	Гэрэл, цахилгаан	11,562,712.00	14,685,032.00
210302	Түлш, халаалт	202,435,425.00	214,531,415.00
210303	Цэвэр, бохир ус	3,141,728.00	5,566,344.00
2104	Хангамж, бараа материалын зардал	97,625,098.00	99,955,753.00
210401	Бичиг хэрэг	14,153,812.00	20,651,854.00
210402	Тээвэр, шатахуун	62,351,368.00	40,661,058.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,132,932.00	21,289,478.00
210404	Ном, хэвлэл	-	8,124,007.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	986,986.00	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	8,329,356.00

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	6,505,400.00	36,084,900.00
210502	Хоол, хүнс	-	2,166,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,505,400.00	33,918,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,834,130.00	18,134,105.00
210604	Урсгал засвар	37,834,130.00	18,134,105.00
2107	Томилолт, зочны зардал	93,817,852.00	97,073,254.00
210702	Дотоод албан томилолт	23,773,700.00	16,690,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	70,044,152.00	80,382,554.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	772,584,293.30	1,109,237,608.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	768,821,105.30	1,105,584,816.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,795,780.00	2,193,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	464,208.00	459,742.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00
210807	Газрын төлбөр	-	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,177,276.09	315,349,239.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,885,652.00	121,043,875.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,066,800.00	4,944,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	174,224,824.09	189,360,564.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,974,441.00	25,755,719.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,994,500.00	23,875,719.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,994,500.00	23,875,719.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,979,941.00	1,880,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,979,941.00	1,880,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	375,284,437.61	258,242,498.26
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	14,234,000.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	14,234,000.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	76,082,500.00	3,782,183.14
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,782,183.14
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	76,082,500.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(61,848,500.00)	(3,782,183.14)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	313,435,937.61	254,460,315.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,709,814,975.30	3,513,119,634.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	360,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	360,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	360,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	360,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,709,454,975.30	3,513,119,634.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	416,581,348.30	813,285,940.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	129,961,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,332,485.30	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	348,248,863.00	683,324,040.60
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,287,076,100.00	2,699,833,694.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,287,076,100.00	2,699,833,694.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,797,527.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,797,527.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,443,606,638.30	3,266,664,328.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,443,606,638.30	3,266,664,328.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,382,632,197.30	3,239,416,209.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	987,566,284.00	1,199,764,506.00
210101	Үндсэн цалин	616,282,685.00	761,884,332.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,099,000.00	88,617,907.67
210105	Гэрээт ажлын хөлс	314,184,599.00	349,262,266.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,091,313.00	138,754,826.00
210201	Тэтгэврийн даатгал	80,571,680.00	94,058,477.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,154,048.00	11,065,750.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,241,357.00	8,728,241.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,803,351.00	2,108,971.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,320,877.00	22,793,387.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,071,565.00	234,782,791.00
210301	Гэрэл, цахилгаан	11,494,412.00	14,685,032.00
210302	Түлш, халаалт	202,435,425.00	214,531,415.00
210303	Цэвэр, бохир ус	3,141,728.00	5,566,344.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,707,947.00	104,832,689.00

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	13,999,768.00	20,192,650.00
210402	Тээвэр, шатахуун	62,993,261.00	39,480,235.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,132,932.00	21,289,478.00
210404	Ном, хэвлэл	-	12,622,267.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	986,986.00	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,595,000.00	10,348,059.00
2105	Нормативт зардал	6,505,400.00	23,247,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,505,400.00	23,247,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,503,184.00	11,108,777.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	435,500.00	1,936,380.00
210602	Тавилга	52,067,684.00	-
210604	Урсгал засвар	-	9,172,397.00
2107	Томилолт, зочны зардал	86,621,909.00	101,285,144.00
210702	Дотоод албан томилолт	23,773,700.00	16,690,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	62,848,209.00	84,594,444.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	784,329,718.30	1,287,832,324.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	780,566,530.30	1,284,179,532.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,795,780.00	2,193,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	464,208.00	459,742.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00
210807	Газрын төлбөр	-	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,234,877.00	137,807,952.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,917,477.00	132,863,152.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,317,400.00	4,944,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,974,441.00	27,248,119.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,994,500.00	25,368,119.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,994,500.00	25,368,119.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	27,000,000.00	1,880,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,000,000.00	1,880,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,979,941.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,979,941.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	266,208,337.00	246,455,306.60
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	151,421,930.00	124,412,890.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	151,421,930.00	124,412,890.00
2200	Дотоод эх үүсвэрээр	151,421,930.00	124,412,890.00
222001	Тоног төхөөрөмж	64,799,040.00	66,153,900.00

223001	Бусад хөрөнгө	86,622,890.00	58,258,990.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(151,421,930.00)	(124,412,890.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,335,190,111.52	151,316,552.24	42,660,480.65	1,529,167,144.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,335,190,111.52	151,316,552.24	42,660,480.65	1,529,167,144.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	313,435,937.61	313,435,937.61
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,335,190,111.52	151,316,552.24	356,096,418.26	1,842,603,082.02
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,335,190,111.52	151,316,552.24	356,096,418.26	1,842,603,082.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,335,190,111.52	151,316,552.24	356,096,418.26	1,842,603,082.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	254,460,315.72	254,460,315.72
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,335,190,111.52	151,316,552.24	610,556,733.98	2,097,063,397.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				
		2,972,318,100.00	2,699,833,694.00	272,484,406.00	90.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ				
		2,972,318,100.00	2,699,833,694.00	272,484,406.00	90.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ				
		2,946,918,100.00	2,672,585,575.00	274,332,525.00	90.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил				
		1,217,195,700.00	1,199,764,506.00	17,431,194.00	98.57
210101	Үндсэн цалин				
		768,322,900.00	761,884,332.33	6,438,567.67	99.16

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,932,000.00	88,617,907.67	9,314,092.33	90.49
210105	Гэрээт ажлын хөлс	350,940,800.00	349,262,266.00	1,678,534.00	99.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,149,500.00	138,754,826.00	13,394,674.00	91.20
210201	Тэтгэврийн даатгал	103,461,800.00	94,058,477.00	9,403,323.00	90.91
210202	Тэтгэмжийн даатгал	12,171,800.00	11,065,750.00	1,106,050.00	90.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,737,600.00	8,728,241.00	1,009,359.00	89.63
210204	Ажилгүйдлийн даатгал	2,434,400.00	2,108,971.00	325,429.00	86.63
210205	Эрүүл мэндийн даатгал	24,343,900.00	22,793,387.00	1,550,513.00	93.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	277,439,100.00	234,782,791.00	42,656,309.00	84.62
210301	Гэрэл, цахилгаан	27,838,800.00	14,685,032.00	13,153,768.00	52.75
210302	Түлш, халаалт	225,480,300.00	214,531,415.00	10,948,885.00	95.14
210303	Цэвэр, бохир ус	24,120,000.00	5,566,344.00	18,553,656.00	23.08
2104	Хангамж, бараа материалын зардал	161,642,000.00	104,832,689.00	56,809,311.00	64.85
210401	Бичиг хэрэг	36,000,000.00	20,192,650.00	15,807,350.00	56.09
210402	Тээвэр, шатахуун	70,796,000.00	39,480,235.00	31,315,765.00	55.77
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,592,000.00	21,289,478.00	8,302,522.00	71.94
210404	Ном, хэвлэл	12,640,000.00	12,622,267.00	17,733.00	99.86
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэргэгчдийн усгал, ариутгал	1,240,000.00	900,000.00	340,000.00	72.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,374,000.00	10,348,059.00	1,025,941.00	90.98
2105	Нормативт зардал	23,682,800.00	23,247,200.00	435,600.00	98.16
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,682,800.00	23,247,200.00	435,600.00	98.16
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,348,000.00	60,939,467.00	52,408,533.00	53.76
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,000,000.00	33,063,380.00	936,620.00	97.25
210602	Тавилга	31,450,000.00	19,249,990.00	12,200,010.00	61.21
210604	Урсгал засвар	47,898,000.00	8,626,097.00	39,271,903.00	18.01
2107	Томилолт, зочны зардал	142,781,000.00	97,618,144.00	45,162,856.00	68.37
210702	Дотоод албан томилолт	62,781,000.00	13,023,700.00	49,757,300.00	20.74
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	80,000,000.00	84,594,444.00	(4,594,444.00)	105.74
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	842,680,000.00	797,701,152.00	44,978,848.00	94.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	837,280,000.00	794,048,360.00	43,231,640.00	94.84
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,800,000.00	2,193,050.00	1,606,950.00	57.71
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.00	459,742.00	140,258.00	76.62
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	300,000.00	300,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,000,000.00	14,944,800.00	1,055,200.00	93.41

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	4,944,800.00	1,055,200.00	82.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,400,000.00	27,248,119.00	(1,848,119.00)	107.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,400,000.00	25,368,119.00	31,881.00	99.87
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,400,000.00	25,368,119.00	31,881.00	99.87
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох		1,880,000.00	(1,880,000.00)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,972,318,100.00	2,699,833,694.00	272,484,406.00	90.83
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,972,318,100.00	2,699,833,694.00	272,484,406.00	90.83
132001	Орон нутгийн төсвөөс	2,972,318,100.00	2,699,833,694.00	272,484,406.00	90.83
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	91.00	91.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	34.00	34.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	813,285,940.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	813,285,940.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	813,285,940.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	546,300.00
210604	Урсгал засвар	-	546,300.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,667,000.00
210702	Дотоод албан томилолт	-	3,667,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	564,167,072.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	564,167,072.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	122,863,152.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	122,863,152.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	122,042,416.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		122,042,416.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	813,285,940.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	813,285,940.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	129,961,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	683,324,040.60

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Н.Хонгорзул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийх, чанар байдлыг тодорхойлж шийдвэрлүүлэх, авлагын үлдэгдлийг холбогдох этгээдтэй тооцоо нийлж баталгаажуулах, элэгдлийн шимтгэлээр анхны үнийг нь бүрэн нөхсөн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх, жил бүр давтагдан орох орлогыг үндсэн үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөгөө батлуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт ажилтан Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн ЗДТГ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ний өдрийн 4/97 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорноговь аймгийн ЗДТГ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны цэвэр хөрөнгийн 1,882,287.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,822.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд цэвэр хөрөнгийн 2,097,063.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 20,970.6 мянган төгрөгөөр тооцож материаллаг байдлын хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

АЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 241,559.1 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	114,786.4	122,042.4	7,256.0
Урьдчилгаа			
Бараа материал	98,849.9	298,743.7	199,893.8
Үндсэн хөрөнгө	1,641,868.0	1,676,277.3	34,409.3
Нийт хөрөнгө	1,855,504.3	2,097,063.4	241,559.1
Өр төлбөр	12,901.2		-12,901.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,842,603.1	2,097,063.4	254,460.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,855,504.3	2,097,063.4	241,559.1

Авлага дансны үлдэгдэл 122,042.4 мянган төгрөг болж 7,256.0 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны оны эцсийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэл 2017 оноос үүссэн бөгөөд жил бүрийн нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангаас авах авлагаар тусгасан авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 298,743.7 мянган төгрөг болж 199,893.8 мянган төгрөгөөр өссөн нь ковид-19-д зориулж байгууллага, ард иргэдээс хандивласан материалын хандив, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор худалдан авсан өвс тэжээлийн үнэ зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,676,277.3 мянган төгрөг болж 34,409.3 мянган төгрөгөөр өссөн нь конторын барилгад их засвар хийж засварын үнийг барилгын өртөгт оруулан тооцож үнийг нэмэгдүүлснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь нийт 227,552.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн буюу хөрөнгө оруулалтаар 48,069.9 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 124,412.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 55,069.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө нийт 107,427.1 мянган төгрөгөөр хасагдсан байна. Үүнд: Үнэ төлбөргүй шилжүүлсэн 61,539.4 мянган төгрөг, акталсан 45,887.7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,097,063.4 мянган төгрөг болж 254,460.3 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн төсвийг 272,484.4 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

АЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 551,585.8 мянган төгрөгөөр буюу 18.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан шалтгаан нь Монгол Улсын ерөнхийлөгч БНХАУ-д бэлэглэх 30000 толгой хониноос Дорноговь аймгаас бэлтгэх 14000 толгой хонины зардал болох 204,183.0 мянган төгрөг ХХААХҮЯ-с, Засгийн газрын 198 дугаар тогтоолоор ковидын эсрэг зардал 110,000.0 мянган төгрөг, Засгийн газрын нөөц сангаас, өвлийг өнтэй давахад зориулж өвс тэжээлийн үнэ 100,000.0 мянган төгрөг, ковидыг хамтдаа даван туулахын тулд иргэд, аж ахуйн нэгжээс хандивласан материаллаг хандив 85,966.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 103,139.1 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь ковид-19 монгол улсад гарсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 668,627.8 мянган төгрөгөөр буюу 26.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд байна. Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл 232,861.7 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албаны шинэ хууль хэрэгжиж, төрийн үйлчилгээний албан хаагч төрийн алба хаасны нэмэгдэл авдаг болсонтой холбоотой байна. Эд хогшил, урсгал засварын зардал 68,403.4 мянган төгрөгөөр буурсан нь ковид-19 цар тахал гарч төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой байна. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 503502.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 108,573.1 мянган төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдсэн нь ковид-19 цар тахалтай холбоотой Засгийн газрын нөөц сан, ОБЕГ, ХХААХҮЯ-наас нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн зардлууд байна. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 20,373.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,684,768.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,684,768.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 12/09 дүгээр тогтоолоор төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөл 2,684,768.1 мянган төгрөгөөр аймгийн ЗДТГ-ын төсвийг баталсан ба АИТХ-ын 2020 оны 9 сарын 20-ны өдрийн 14/05 тогтоолоор 2,972,318.1 мянган төгрөг болгон анхны баталсан төсвийг 287,550.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж өөрчилсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,972,318.1.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,972,318.1.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,699,833.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, бараа ажил үйлчилгээний зардалд 2672585.6 мянган төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 27248.1 мянган төгрөг зарцуулсан байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

2020 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сангаас 129,961.9 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 350,634.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 332,689.1 мянган төгрөг, нийт 813,285.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал засварт 546.3 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 3,667.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардалд 564,167.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 122,863.1 мянган төгрөг нийт 691,243.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 122,042.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 137 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12901.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	1	12,901.2	1	12,901.2	0	0	0
Зөвлөмж	1		1		0	0	
Нийт дүн	2	12,901.2	2	12,901.2	0	0	0

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4594.4 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс, 4594.4 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 5 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Залруулсан алдаа байхгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчил илэрснээс 1 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 80382,5 сая төгрөг зарцуулсан нь батлагдсан төсвийг 4594.4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46.5-д “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараах арга хэмжээнд зарцуулахыг хориглоно: 46.5.3-д зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн 1 албан шаардлага өгөв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 5 зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц, дараагийн аудитаар авч үзэх зүйл байхгүй байна.

4. Менежментийн захидал

Төрийн аудитын тухай хуулийн 20.2-т заасан “Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө” гэж заасныг үндэслэн дараах зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүлж байна.

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Санхүүгийн байдлын тайлагнагдсан авлага нь нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 122042.4 мянган төгрөгийг төвлөрүүлснээс үүссэн авлага байна. Авлагын задаргааг үзэхэд техник хяналтын зардлын 80137.3 мянган төгрөг, 2019 оны нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 11963.2 сая төгрөг, бусад 29941.9 мянган төгрөг байна. Эдгээр үйл ажиллагааны мөнгөний тооцоог тоолж, холбогдох хүмүүстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, дараа онд тус авлагыг хүлээн аваад ямар арга хэмжээнд зарцуулах нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна, 12.2. Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл: хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль, эрх зүй зөрчигдөх

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: АЗДТГ-ын даргын 2020.10.12-ны А/127 дугаар тушаалаар тооллогын комисс томилсон байна. Комисс нийт 2,516,812.7 мянган төгрөгийн бараа материалын болон үндсэн хөрөнгийг тоолсон байна. Жилийн эцсийн бараа материалын тайланд 105,116.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн үлдэгдэл тайлагнагдсан ба өвс тэжээлийн үлдэгдлийг тоолоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Холбогдох эрх зүйн акт зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж: Байгууллагад бүртгэлтэй бүх хөрөнгийг хамруулж хуульд заасан хугацаанд тооллого хийж, тооцоо бодох

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн журналд элэгдлийн шимтгэлээр анхны үнээ бүрэн нөхсөн 392,288.3 мянган төгрөгийн 218 хөрөнгө байна. Үүнд: Тээврийн хэрэгсэл дансанд 166,867.8 мянган төгрөгийн 2 машин, 164,648.8 мянган төгрөгийн 102 тоног төхөөрөмж, 59,883.6 мянган төгрөгийн 109 тавилга эд хогшил, 288.1 мянган төгрөгийн бусад хөрөнгө, 600.0 мянган төгрөгийн программ хангамж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д “худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх; илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Аймгийн ИТХТ-ийн 2019.11.15-ны өдрийн 70 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.2-т “Байгууллагын хөрөнгийн тооллогын комиссоос хагас бүтэн жилээр зохион байгуулсан тооллогын дүнг хэлэлцэж дутагдуулсан, ашиглалтгүй байгаа, цаашид ашиглах шаардлагагүй, боломжгүй болсон хөрөнгийн шалтгааныг тогтоож дутагдуулсан, илүүдэлтэй хөрөнгийн жагсаалт гарган хэрхэн шийдвэрлэх талаар байгууллагын удирдлагад санал дүгнэлт хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл: Эрх зүйн акт зөрчигдөх, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийн тоо олшрох, оршин байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх

3.3. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3 дахь заалтыг хэрэгжүүлэх, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн асуудлыг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэж, байгууллагын удирдлагад санал дүгнэлт хүргүүлж шийдвэрлүүлэх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

4. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал

4.1.Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын төсвөөс төсөвт байгууллагуудад 143190.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын шинж чанартай дэмжлэг, тусламж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25.10-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2 Эрсдэл: Хууль, эрх зүй зөрчигдөх

4.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 25.10 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

5. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт: АЗДТГ-ын 2020 оны анхны батлагдсан төсөв 2,684,768.5 мянган төгрөг байсан ба төсвийн тодотголоор нийт 287,549.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн төсвөөс 2,972,318.1 төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Тайлант хугацаанд

2,699,833.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь батлагдсан төсвөөс 272,484.4 мянган төгрөгөөр дутуу байна. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд нийт 683,324.0 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна. Үүнээс Захиалагчийн хяналт тавих зардлын 30 хувь болох 107,838.8 мянган төгрөгийн орлого, архивын үйлчилгээний орлого 14,086.2 мянган төгрөгийн орлого бүрдсэн ба жил бүр давтагдан ордог энэ 2 төрлийн орлогыг /121,925.0 мянган төгрөг/ үндсэн үйл ажиллагаанаас орох орлогоор төлөвлөж батлуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4-т "Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг хориглоно", 3.4.3-т "Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.2 Эрсдэл: Үндсэн үйл ажиллагааны орлогыг хяналтгүйгээр үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль, эрх зүй зөрчигдөх

5.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4-т заасныг хэрэгжүүлж ажиллах

5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021 он	Аудитын нэр: Дорноговь аймгийн ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/116/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дорноговь аймгийн ЗДТГ	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	-	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Н.Хонгорзул, Х.Сосормаа
2	Өвс, тэжээлийн үлдэгдлийг тоолж, тооцоо бодоогүй	-	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Н.Хонгорзул, Х.Сосормаа
3	Элэгдлийн зардлаараа анхны үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй	-	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Н.Хонгорзул, Х.Сосормаа
4	Байгууллагуудад хөрөнгө оруулалтын шинж чанартай дэмжлэг, тусламж олгосон	-	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Н.Хонгорзул, Х.Сосормаа
5	Жил бүр давтагдан ордог орлогыг үйл ажиллагааны орлогоор төлөвлөж, төсөвт суулгаагүй	-	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Н.Хонгорзул, Х.Сосормаа
6	Зочин төлөөлөгч хүлээн авах зардлын төсвийг хэтрүүлсэн	4594.4	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Н.Хонгорзул, Х.Сосормаа
ДҮН		4594.4			